



НИЙСЛЭЛИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2015 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/62

Улаанбаатар хот

Нийслэлийн эх барих, эмэгтэйчүүдийн тусламж
үйлчилгээний хүрээнд зарим өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын "Эх барих эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүрээг шинэчлэн батлах тухай" 2013 оны 362 дугаар тушаал, Нийслэлийн эрүүл мэндийн газрын дүрмийн 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Амгалан амаржих газрын 150 ортой барилга ашиглалтанд орсонтой холбогдуулан Нийслэлийн амаржих газруудын ачааллыг тэнцвэржүүлэх, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор Өргөө амаржих газраар үйлчлүүлж байсан Сүхбаатар дүүргийн иргэдийн эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээг Амгалан амаржих газарт 2015 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс шилжүүлэн зохион байгуулсугай.
2. Бусад дүүргийн эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээг Эрүүл мэндийн сайдын 2013 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 362 дугаар тушаалын хавсралтанд заагдсан хуваарийн дагуу үргэлжлүүлэн үзүүлсүгэй.
3. Тусламж үйлчилгээний хүрээнд гарсан өөрчлөлттэй холбоотой эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Мэргэжлийн удирдлага, бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс /Т.Хулан/-т үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Б.Ганбат-д даалгасугай.

ДАРГА



Ш.ЭНХБАТ

1150500192